



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

**Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт
өөрчлөлт оруулах тухай**

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмын 9.5 дахь заалт “Ажилтан, албан хаагчид сард ажилласан хоногоор тооцон нэг өдрийн хоолны мөнгө 2600 төгрөг, унааны тал зардал болох 500 төгрөгөөг тооцон олгоно” -ыг “Ажилтан, албан хаагчид сард ажилласан хоногоор тооцон нэг өдрийн хоолны мөнгө 5000 төгрөг, унааны зардлыг 1000 төгрөгөөг тооцон олгоно” гэж өөрчилсүгэй.

2. Хөдөлмөрийн дотоод журмын дээрх нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, тус журмыг албан хаагчдад танилцуулж, холбогдох арга хэмжээ авахыг Захиргаа санхүү, төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн /П.Түвшинзаяа/-д даалгасугай.

ДАРГА  М.ГОНЧИГЖАВ



3150600058